



**НИЙСЛЭЛИЙН БАЯНГОЛ ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 10 сарын 25 өдөр

Дугаар 1/459

Улаанбаатар хот

“Шимт өргөө” сууц өмчлөгчдийн холбоонд  
шинээр гэрчилгээ олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6.л, 29.2, Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1, 18.1.3 дах заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Баянгол дүүргийн 18 дугаар хорооны 64, 65, 18а, 18 дугаар байрны “Шимт өргөө” сууц өмчлөгчдийн холбооноос 2021 оны 08 дугаар сарын 04-ний өдөр гаргасан хүсэлт, холбогдох материалыг үндэслэн шинээр гэрчилгээ олгосугай.

2.Нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн хэвийн байдлыг хангах, сууц өмчлөгчдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах, дундын өмчлөлийн эд хөрөнгийн эзэмшил, ашиглалт, арчлалт, хамгаалалтыг эрхлэн хариуцаж ажиллахыг “Шимт өргөө” сууц өмчлөгчдийн холбоонд үүрэг болгосугай.

3.Дүүргийн сууц өмчлөгчдийн холбоодын бүртгэлд зохих өөрчлөлтийг хийж, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тохижилт, Нийтийн аж ахуйн хэлтэст үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ө.СУМЬЯАБААТАР